



# Цоорхойн Рашаан

БНХАУ-ын ШУА-ийн Шинжааны Экологи, Газарзүйн хүрээлэн, Монгол Улсын ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны салбартай хамтарсан "Хээрийн бүсэд цөлжилттэй тэмцэх технологийн туршилт судалгаа" төслийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших Цоорхойн рашаан уснаас дээж авч тодорхойлов. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Усны чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 4586:1998"-н шаардлага хангаж байна.

## Цоорхойн Рашааны байршил



Энэхүү рашаан нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5-р багийн нутаг Чойрын богд уулнаас баруун тийш х.ө  $46^{\circ} 12'11''$ , з.у  $108^{\circ} 41'12,4''$ , далайн түвшнээс дээш 1370м өндөр оршдог. Цоорхойн рашаан нь хүний дотор эрхтэнд сайн хэмээн нутгийн иргэд ундны усандаа хэрэглэж иржээ. Нутгийнхан рашаан хэмээн дээдэлж магнайдаа хүргэн амсдаг нь ариун дагшин байгалиа хайрлаж ирсэн уламжлалтай. Газрын хөрснөөс даруухан цоолдон гарч ундардаг тул цоорхой рашаан хэмээн нэрлэх болжээ. 2018 онд тус рашааныг аялал жуулчлалын зориулалтаар тохижуулсан байна.